

4. ТАНАЙ СУМЫГ ЗОРИН ИРЭХ ИРГЭДЭД ЯМАР БОЛОМЖ, НӨХЦӨЛ ОЛГОХ ВЭ?

- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 10 давхар орон сууц баригдаж, залуу гэр бүл болон иргэдийн ая тухтай амьдрах орчинг бүрдүүлнэ



- Иргэдэд өмчлөлийн болон эзэмшлийн газар олголтыг үргэлжлүүлэн олгоно.

- СУ, GS25 зэрэг 24 цагийн ажиллагаатай худалдааны сүлжээ дэлгүүр үйл ажиллагаа явуулж байна.

- ХАА-н ложистик төв байгуулагдсанаар жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжинэ.

- Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагаар дамжуулан сумынхаа иргэдэд бага хүүтэй хөнгөлөлттэй зээл олгох


- Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор сум хөгжүүлэх сангийн зээлийг түлхүү олгох

- Хүүхдийн тоглоомын иж бүрэн талбайг шинээр ашиглалтад оруулсан. Хүүхэд залуусын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчин бий болсон.

- Иргэдийн чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, төрөл бүрийн уралдаан тэмцээн зохион байгуулах ажлыг эрчимжүүлж спорт заалыг иж бүрэн засварласан.

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгодог зээлийг олгох /малжуулах төсөлд хамруулах, Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зээл, жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих зээл, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зээл гэх мэт/

- Шилжин ирж буй төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдэл, улсын хэмжээнд 3 аймагт олгогдож буй төрийн албан хаагчдад олгох орон нутгийн 50 хувийн нэмэгдэл цалин олгодог /2024 онд орон нутгийн нэмэгдлийг 100 хувьд хүргэхээр төлөвлөсөн/



НЭЭЛТТЭЙ СЭЛЭНГЭ



“СЭЛЭНГИЙН ИРЭЭДҮЙ- ТОГТВОРТОЙ НОГООН ХӨГЖИЛ”

БАЯНГОЛ СУМЫН ОНЦЛОГ ДАВУУ ТАЛ:

Сэлэнгэ аймгийн Баянгол сум нь 1931 онд Богдхануулынаймгийн Баатарвангийнхошууны Хөлий-Баянуул сумын суурин дээр Түнхий аманд Хараа голын хөндийд байгуулагдан 1954 онд Мандах нэгдэл нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байгаад 1968 онд Баруунхараа САА болон өргөжин 1992 онд шинэ Үндсэн хуулиар Баянгол сум болон цэцэглэн хөгжиж байна. Тус сум нь 197.6 мянган га газар нутагтай, засаг захиргааны анхан шатны нэгж 3 багтай, 5702 хүн амтай 1682 өрхтэй, төсвийн 10 байгууллагатай.



99975014



<http://bayangol.se.gov.mn/>



Баянгол сум нь Улаанбаатар хотоос 154 км, Аймгийн төв Сүхбаатар хотоос 170 км, Дархан-уул аймгийн төвөөс 75 км зэргэлдээ Мандал сумаас 35 км зайд тус тус оршдог. Сумын төвөөр олон улсын төмөр зам болон автозам дайран өнгөрдөг, үүрэн холбооны бүх операторын сүлжээтэй, төвлөрсөн халаалтын системтэй, дэд бүтцийн хөгжлөөрөө давуу талтай. Газар тариалан, мал ажахуй хослуулан эрхэлдэг онцлогтой.



СУМЫН ХӨГЖИХ БОЛОМЖ:

Орон нутгийн хөгжлийн гол зорилго нь олон улсын чанартай зам харилцааг түшиглэн хүний хөгжил, ая тухтай амьдрах орчин бүрдүүлэхэд чиглэдэг бөгөөд нутгийн захиргаа, нийгмийн үйлчилгээ, дэд бүтэц, иргэдийн аж ахуй эрхлэх боломж /Эрчимжсэн мал аж ахуй, Газар тариалан, хүнсний ногоо/ зэрэг харилцааг хөгжүүлэх боломжтой.

ХОТ ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БУЙ БОЛОН ХИЙГДЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ АЖИЛ, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖИЛ:

- Баянгол суманд Хөдөө аж ахуйн төв буюу ложистик төвийн барилга улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байна. Ложистик төв баригдаж ашиглалтад орсноор малчид, ногоочид, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг ажлын байраар хангах, сумын иргэдийн амьжиргааг дээшлүүлэхээс гадна ойролцоох аймаг, сум, хотуудын иргэдийн түүхий эд, бараа бүтээгдэхүүнээ борлуулах нөхцөл боломж бүрдэнэ. Авто замаар зорчигчдыг хүнсний бүтээгдэхүүнээр хангаж хөрөнгө оруулалтыг сумандаа оруулна.

- Орчин үеийн хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн зураг төсвийг хийж Улсын төсөвт суулгах саналыг хүргүүлсэн. Цэвэрлэх байгууламж шинэчлэгдсэнээр дэд бүтэц сайжрах аас гадна Арьс ширний үйлдвэр байгуулж, малын түүхий эдийг боловсруулах борлуулах, зах зээлийн таатай нөхцөл бүрдэнэ.

- Сумын уурын зуухны шинэчлэлийн

ажил 2022 онд ОНХС-ын хөрөнгө оруулалтаар хийгдсэн. Мөн 2023 онд дахин нэг зууханд шинэчлэл хийхээр нээлттэй тендер зарлаад байна. Халаалтын хүчин чадал нэмэгдсэнээр төвийн хэсгийн гэр хорооллыг дулааны шугамд холбох боломжтой болно.

- Сумын төвийн зам харилцааг сайжруулж Гонир 3-р багийн гэр хорооллын замыг хатуу хучилттай болгож мөн олон улсын авто замын Сондор дэлгүүрийн уулзвараас Зүүнхараа чиглэлийн 1.6 км замыг хатуу хучилттай болгохоор ажиллаж байна. Цаашид орон сууцны хорооллын дундах авто зам, Гонир баг ургамлын тосны үйлдвэр лүү чиглэсэн замуудыг хатуу хучилттай болгохоор төлөвлөөд байна.

- Сумын төвийн гэрэлтүүлгийн засварын ажлыг төсвийн хөрөнгөөр хийж гэрэлтүүлгийн бүрэн байдлыг хангасан.

- Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор Хараа, Баян, Гонир багийн хөдөөгийн хэсгүүдэд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар худаг гаргасан.

- Малын эрүүл мэндийг хамгаалах халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ариутгалын ДҮК машин, орчны эрүүл ахуйн шаардлагыг хангаж хоггүй орчин бий болгох зорилгоор ковш зэргийг малын тоо толгойн албан татвараас худалдан авч ашиглаж байна.

- Сумын хэмжээнд Баян, Хараа, Гонир багт мал угаалгын ванныг Орон нутгийн сангийн хөрөнгө оруулалтаар хийж ашиглаж байна.

